



1925

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Г Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.2, 43.2.3 дахь заалт, 120 дугаар зүйлийн 120.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаал, Байгууллагын Хамтын гэрээний 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Эмнэлгийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 3 дугаар зүйлийн 3.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус эмнэлгийн “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Зөвлөлийн гишүүний Албан тушаалын тодорхойлолтод нэмэлт чиг үүргийг тусган батлуулж, ажилтанд танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга (П.Мөнхтуул)-д үүрэг болгосугай.

3. Зөвлөлийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах зардлыг тухай бүр танилцуулан шийдвэрлүүлж ажиллахыг Санхүү, бүртгэлийн алба (Н.Урансүрэн)-нд даалгасугай.

4. Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллахыг Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Б.Түвшинтөр)-д даалгасугай.

5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан эмнэлгийн Ерөнхий захирлын 2019 оны А/213 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАНҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Б.ХИШИГЖАРГАЛ

002388

ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам			
 УЛСЫН НЭГДҮГЭЭР	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 3	Журмын дугаар.....
			УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ОРОН ТООНЫ БУС
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан
- Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны эрсдэлийн менежер
- Гишүүн: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга
- Халдварын сэргийлэлт хяналтын албаны дарга
- Сувилахуйн албаны дарга
- Дүрслэл оношилгооны төвийн цөмийн онош зүйн тасгийн их эмч
- Санхүү, бүртгэлийн албаны үндсэн хөрөнгийн нягтлан бодогч
- Ажилтнуудын төлөөлөл: Техникийн албаны хүчилтөрөгчийн инженер
- Нийгмийн эрүүл мэндийн албаны хоол зүйч

ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам			
УЛСЫН НЭГДҮГЭЭР	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

Улсын нэгдүгээр төл эмнэлгийн ерөнхий захирлын 2024 онд ... дүгээр сарын ...-ны өдрийн А/06 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



УЛСЫН НЭГДҮГЭЭР

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ОРОН ТООНЫ БУС
ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

2024 он

 УЛСЫН НЭГДҮГЭЭС	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

БАТАЛГААЖИЛТ

Энэхүү журмыг боловсруулсан, хянасан, баталсан болоод хүчин төгөлдөр байдлыг дараахь хүснэгтээр баталгаажуулна

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ	ОГНОО
БОЛОВСРУУЛСАН	ХАБЭА-н ажилтан	Ж. Урантөгс		2023.11.....
ХЯНАСАН	Төлөвлөлт, үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал	Б.Түвшинтөр		2023.11.....
	Хуулийн зөвлөх	Ш. Нарантуяа		2023.11.....

 УЛСЫН НЭГДЛЭГ ЗЭР	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмыг жилд 1-ээс доошгүй удаа хянана. Журамд тусгах шаардлагатай өөрчлөлтийг хэлэлцэж удирдлагаар баталгаажуулна. Журамд орсон өөрчлөлтийг доорхи “Өөрчлөлтийн бүртгэл”-д тэмдэглэнэ.

[illegible]

 УРСЬ И НЭГДЭГ ДЭР	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

АГУУЛГА

д/д	Гарчиг	Хуудас
1.	Нийтлэг үндэслэл	5
2.	Нэр томьёо ба тодорхойлолт	5
3.	Урсгал диаграмм	6
4.	Үндсэн үйл ажиллагаа	7-8
5.	Эрх үүрэг	8-9
6.	Хариуцлага	9
7.	Гүйцэтгэлийн шалгуур (хэмжүүр)	9
8.	Холбогдох баримт бичиг	10
9.	Бусад	10

 УЛСЫН НЭГДҮГЭЭСЭР	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЭЗЭЖ

1. Нийтлэг үндэслэл.


- 1.1. Энэ журмын зорилго нь Улсын нэгдүгээр төв эмнэлгийн/цаашид байгууллага, зарим тохиолдолд эмнэлэг гэх/ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэнэ/ -ийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдэнэ.
- 1.2. Зөвлөл нь байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэн ажиллана.
- 1.3. Зөвлөл нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгон үйл ажиллагаагаа явуулна.
- 1.4. Зөвлөлийн энэ журмаар зохицуулаагүй үйл ажиллагааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.5. Зөвлөл нь тухайн жилийн үйл ажиллагаагаа байгууллагын удирдлага, хамт олонд жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор тайлагнана.
- 1.6. Зөвлөл үйл ажиллагааныхаа тайлан, мэдээг дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд 12 дугаар сарын 15-ны дотор багтаан хүргүүлнэ.

2. Нэр томъёо ба тодорхойлолт

- 2.1. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо" гэж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаархи бодлого, зорилтыг тодорхойлох, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, манлайлах, хяналт тавих, үнэлгээ хийх харилцан холбоо бүхий удирдлагын үйл ажиллагааны цогцыг;
- 2.2. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт" гэж хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар эрх бүхий байгууллагаас тогтоосон хэм хэмжээг.

 УЛСЫН НЭГДЭГЭЭР	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

3. Урсгал диаграмм



 УЛСЫН НЭГДҮГЭЭС	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

4. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт, үйл ажиллагааны хэлбэр

4.1. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт

- 4.1.1. Зөвлөл нь тухайн байгууллагын ажилтны тооноос хамааран ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий 9 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байна.
- 4.1.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар баталж, шинэчилнэ. Зөвлөлийн бүрэлдэхүүнд ажилтны төлөөллийг заавал оруулна.
- 4.1.3. Зөвлөлийг байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал ажилтан ахална.
- 4.1.4. Зөвлөлийн ажиллах журмыг эмнэлгийн Ерөнхий захирлын тушаалаар баталж, нэмэлт, өөрчлөлт оруулна. Зөвлөл энэ журмыг удирдлага болгон ажиллана.
- 4.1.5. Зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг эмнэлгийн Ерөнхий захирал 2 жилийн хугацаагаар томилно.
- 4.1.6. Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг Зөвлөл хурлаараа хэлэлцэн баталж, хэрэгжүүлж ажиллана.
- 4.1.7. Зөвлөлийн дарга зөвлөлийн үйл ажиллагааг нэгдсэн мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, ажлын үр дүнг Ерөнхий захирлын өмнө хариуцна.
- 4.1.8. Зөвлөлийн гишүүд Зөвлөлийн даргын нэгдсэн удирдлагад Албан тушаалын тодорхойлолтод заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр ажиллах үүргээ биелүүлж, ажиллана.
- 4.1.9. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурлын бэлтгэлийг хангах, тэмдэглэл хөтлөх болон зөвлөлийн үйл ажиллагааны явцад зохион бүрдүүлэх албан хэрэг хөтлөлтийг бүрэн хариуцаж, архивын нэгж болгон эмнэлгийн архивт хүлээлгэн өгөх ажлыг хариуцна.

4.2. Зөвлөлийн хурал

- 4.2.1. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Улиралд 1-ээс доошгүй удаа / улирал бүрийн эхний сард /хуралдана. Шаардлагатай бол Зөвлөлийн дарга ээлжит бус хурлыг зарлах эрхтэй байна.
- 4.2.2. Зөвлөлийн хурлыг нийт гишүүдийн 50-иас дээш хувийн ирцтэй хийнэ.
- 4.2.3. Зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга товлон зарлаж, удирдан явуулна.
- 4.2.4. Зөвлөлийн гишүүд хуралд саналын эрхтэй оролцоно.Хурлаар асуудал хэлэлцүүлэх тохиолдолд бэлтгэлийг сайтар хангана.

 ХҮҮЛЬ Н НЭГДЭГ ДЭВ	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

- 4.2.5. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, шийдвэрийг хурлын тэмдэглэлд тусган дарга, нарийн бичгийн дарга, гишүүд гарын үсэг зурна.
- 4.2.6. Зөвлөл нь өөрийн чиг үүргийн хүрээний асуудлаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлага, зөвлөмж гарган эмнэлгийн холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. Шаардлага, зөвлөмжийг холбогдох нэгж, албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй.
- 4.2.7. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан байгууллагын холбогдох алба, нэгжийн ажилтнуудыг хуралд оролцуулж болно.
- 4.2.8. Зөвлөл нь байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хэлэлцүүлэг хийх, санал хусэлтийг хүлээн авах, зөвлөлдөх, зөвлөмж, санал гаргах, шаардлага өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад оролцох чиглэлээр ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран ажиллана.

5. Зөвлөлийн эрх, үүрэг

5.1. Зөвлөлийн эрх:

- 5.1.1. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг, шалгалт хийх ажилд тухайн асуудал хариуцсан албан тушаалтан, мэргэжлийн хүмүүс, ажилтныг татан оролцуулах, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлого, үйлдвэрлэлийн аюултай хортой хүчин зүйлийн талаар мэдээлэл гаргуулан авах;
- 5.1.2. Төв тасаг, албадын удирдлагуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны нөхцлийг сайжруулж, хөдөлмөрийн тааламжтай нөхцлийг бий болгох, гарч болзошгүй осол, эндэгдэл, өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээ авах талаар шаардлага тавих;
- 5.1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, тогтоомж зөрчсөн албан тушаалтан, ажилтанд хариуцлага хүлээлгэх талаар ажил олгогчид санал тавих;
- 5.1.4. Байгууллагын удирдлагад хөдөлмөрийн эрүүл, аюулгүй нөхцлийг бий болгох, сайжруулахад идэвхи санаачилгатай ажилласан хувь хүн, хамт олныг урамшуулах санал оруулах;
- 5.1.5. Хууль тогтоомжоор олгосон бусад эрх.

5.2. Зөвлөлийн үүрэг:

- 5.2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах;

 УЛСЫН НЭГДЛЭГ ЗЭВ	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /.....	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

- 5.2.2. Аюулгүй байдал эрүүл ахуйн асуудлаар байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр төлөвлөгөө, төсөвт тусгах асуудлыг боловсруулах, шаардлагатай дүрэм, журмыг баталж, мөрдүүлэхэд санал өгөх, ажил олгогчтой хамтран ажиллах;
- 5.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцлийн талаар хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;
- 5.2.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах ажлыг ажил олгогчтой хамтран зохион байгуулах;
- 5.2.5. Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэхэд оролцох, бүртгэл судалгаатай танилцах, ажил олгогчоос шаардлагатай мэдээлэл гаргуулж авах;
- 5.2.6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, дүнг ажил олгогч, ажилтнуудад мэдээлэх;
- 5.2.7. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ахуйн байрны орчин нөхцөл, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах, хоолны чанарт хяналт тавих, үр дүнг мэдээлэх;
- 5.2.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхижуулах арга хэмжээг ажил олгогчтой хамтран зохион байгуулах;
- 5.2.9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа талаар ажил олгогчийн тайлан мэдээллийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, зөвлөмж, шийдвэр гаргах;
- 5.2.10. Хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүрэг.

6. Хариуцлага

- 6.1. Энэ журмыг зөрчсөн Зөвлөлийн гишүүн болон эмнэлгийн бусад албан хаагч нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

7. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

- 7.1. Журмын хэрэгжилтийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн ажлын үр дүн, тайлан, дүгнэлтийн гүйцэтгэлээр хэмжинэ.

 УЛСЫН ХАМГААГЧИЙН ЗОХИОН ХАМГААГАГЧИЙН ЗОХИОН	ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн ажиллах журам		
	Хүчин төгөлдөр хэрэгжих хугацаа 2024 / /	Хувилбар 3	Журмын дугаар..... УНТЭ-ЗАА-ХАБЭАОТБЗАЖ

8. Холбогдох баримт бичиг

- 8.1. Монгол улсын “Хөдөлмөрийн тухай” хууль, МУ-ын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” хууль.
- 8.2. Холбогдох дээд шатны байгууллагын тогтоол, тушаал, захирамж
- 8.3. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”

9. Бусад

- 9.1. Энэхүү журам нь байгууллагын ерөнхий захирал баталснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 9.2. Энэ журмыг холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэх болон эмнэлгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн харилцааг зохицуулах шаардлагатай тохиолдолд хянаж, Ерөнхий захирлын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулна.